

Дугаар:

ХУРЛЫН ТОВ

Хурал болсон газар	Цахим хурал
Он сар өдөр	2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хуралдав.
Хурлын цаг	10:00-12:00 цагт боллоо.

ХУРЛЫН ИРЦ

Хурлын дарга	ТУЗ-ийн дарга Д.Даянбилгүүн
Хурлын ирц	83.60%
Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид	52 хувьцаа эзэмшигчид

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг батлах
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
6. ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах

Тооллогын комиссын дарга Баярцэцэг:**“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН ХОЙШЛОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

Компанийн тухай хуулийн 67.3.1, 69.1, 69.2, 69.8 болон “Женко тур бюро” ХК-ийн дүрмийн 3.15, “Женко тур бюро” ХК-ийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Женко тур бюро” ХК-ийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хуралд 66,872,680 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 52 хувьцаа эзэмшигч

оролцож, нийт саналын эрх бүхий 79,988,802 ширхэг энгийн хувьцааны 83.6% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дох заалт, компанийн дүрмийн 3.15 дахь заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 83.6%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурлын дарга: Нийт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэнд хүргэе. Женко тур бюро ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэнээр өнөөдөр хуралдах боломжтой болсон байна. Хурлын дэгийн та бүхэнд танилцуулъя.

- Хурлын ирцийг бүртгэх
- Хурлын ирцийг мэдээлэх
- Хурлын дарга хурлыг нээх
- Компанийн танилцуулга
- 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт
- 2019 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан
- 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- 2020 оны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө
- ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалыг хэлэлцэн батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ТУЗ-с гаргасан ноогдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах
- Асуулт хариулт
- Саналын хуудас бөглөх заавар танилцуулах
- Санал хураалт
- Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах
- Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах
- Хурлын дарга хурлыг хаах гэсэн дараалалтай явна.

Компанийн танилцуулгыг гүйцэтгэх захирал Ц.Энхсайхан танилцуулна.


Энхсайхан: Манай компанийн эрхэм зорилго нь Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсан чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох зорилготой. 1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 01 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор Хувьцаат Компани болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

2019 онд ТУЗ-ийн даргаар Д.Даянбилүүн, гүйцэтгэх захирлаар миний бие Ц.Энхсайхан ажиллаж байна. Энэ хугацаанд Женкотур бюро ХК нь жуулчны улиралд 65-70 хүнтэй хамт олон бүрдэн ажилласан. Энэ хугацаандаа томоохон тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэнээс дурьдвал Холевүүдын жүжигчид монголд хөтөлбөрийг Чингисийн морь хөшөө болон 13-р зуун амралтын баазад хүлээн авч монгол орныхоо байгалийн сайхныг

гайхуулж, өөрсдийн өв соёл зан ахуйтайгаа танилцуулсан Мөн Жи-150 Коал монголиа, Монголын талын салхи олон улсын мото спортын хамт олон, Чингисийн үр сад, Хүннү музик фестивал, Түүхийн жимээр, Монгол бахархлын өдөр гэх мэт олон арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

Аялал жуулчлалын салбар нь олон чиг, бүрэлдэхүүн хэсгээс бүртддэг учир манай хамт олон олон талт чадвараа ашиглан зохион байгуулалт, бүтээн байгуулалт, засвар үйлчилгээнийхээ ажлыг хийж гүйцэтгэж ирсэн. Түүнчлэн компанийн бренд болсон сингапур аялалыг амжилттай зохион байгуулсан. Гадаад аялалыг тоо бус чанар дээр анхааран ажилласан нь үйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцсэн. 11 орны 18 удаагийн 300гаад хүний аялал хийсэн. Дотоод аялалд 8 төрлийн 1200 гаруй жуулчдын хамруулсан. 2019 онд манай компани нь 4,7 тэрбумын борлуулалт хийж төлөвлөгөөгөө давуулан биелүүлж, үр ашгаа нэмэгдүүлж ажилласан. Өмнөх жилүүдэд Борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь Борлуулалтын орлогын дунджаар 80%-ийг эзэлдэг байсныг 2019 онд 61% болгон буурлсан нь Нийт ашиг нэмэгдэхэд голлох нөлөө үзүүлсэн.

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он гүйцэтгэл /төгрөгөөр/	2019 он төлөвлөгөө /төгрөгөөр/	2019 он гүйцэтгэл /төгрөгөөр/
Борлуулалтын орлого	4,817,876,206	4,024,115,419	4,702,206,343
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,147,961,114	3,006,488,788	2,864,799,847
Нийт ашиг	669,915,092	1,017,626,631	1,837,406,496
Санхүү ба бусад орлого	722,079	1,000,000	2,812,681
Үйл ажиллагааны зардал	344,991,303	373,123,305	400,974,243
Бусад зардал	58,181,161		41,626,112
Бусад олз, гарз	(32,608,828)		247,295
Татварын өмнөх ашиг	234,855,880	645,503,326	1,397,866,116
Орлогын татварын зардал	32,620,439	64,550,332	144,088,286
Тайлант жилийн цэвэр ашиг	202,235,440	580,952,993	1,253,777,830



2019/2018 гүйцэтгэлийн харьцуулалт:

- 2019 оны нийт орлогын гүйцэтгэлийг 2018 оны нийт орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад -2% бууралттай,
- 2019 оны нийт зардлын гүйцэтгэлийг 2018 оны нийт зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад -25% бууралж танасан,
- 2019 оны нийт цэвэр ашгийн гүйцэтгэлийг 2018 оны нийт ашгийн гүйцэтгэлтэй харьцуулахад 520% өсөлттэй гарсан.

2019 төлөвлөгөөний гүйцэтгэлийн харьцуулалт:

- 2019 оны нийт орлогын төлөвлөгөөг - нийт орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 17% биелсэн,
- 2019 оны нийт зардлын төлөвлөгөөг - нийт зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад 0,2% биелсэн,
- 2019 оны нийт цэвэр ашгийн төлөвлөгөөг - нийт цэвэр ашгийн гүйцэтгэлтэй харьцуулахад 116% биелсэн.

2019 онд Далайван аудит ХХК хараат бус аудитын ажлыг хийсэн.

"Женкотур бюро" ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна. " гэж дүгнэсэн. Аудитын компанийн хязгаарлалттай дүгнэлт гаргасан нь анх хувьцааны 20 сая ширхэг хувьцааны бүртгэл буруу хийгдсэн нь хязгаарлалттай дүгнэлт хийхдэх үндэслэл болсон. Энэхүү бүртгэлийн ажлыг залруулах боломжтой.

2020 оны төлөвлөгөө нь дэлхий нийтээр тархаад байгаа COVID-19 цар тахлын нөлөөгөөр өмөн нь төлөвлөж байсан борлуулалтын орлого 5,4 тэрбум хараахан биелэгдэх боломжгүй болсон. Төлөвлөгөөгөө цаг үетэй холбоотойгоор дахин төлөвлөж ашигтай ажиллахыг төлөө хичээх болно.

Хурлын дарга: 2019 оны ерөнхий тайлангаа тавьсан гүйцэтгэх захиралдаа талархлаа илэрхийлье.

2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт

Хурлын танилцуулгын ном дээр дэлгэрэнгүй байгаа. 2019 онд Манай компанийн хувьд онцлууштай жил болж өнгөрлөө. Компанийн ашиг орлого анх удаагаа тэрбум төгрөг давж 1,4 тэрбум ашигтай ажиллаа. Энэ нь манай төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын багийн хамтын ажиллагаа, ажлын хамт олны мэрийлт, чармайлт байсан гэж төлөөлөн удирдах зөвлөл дүгнэсэн байгаа. Компани 2019 онд 4.7 тэрбумын борлуулалт хийж төлөвлөгөөний биелэлт 117%, татварын өмнөх цэвэр ашиг 1.4 тэрбум сая төгрөгт хүрч төлөвлөгөөний биелэлт 216%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. ТУЗ-ийн хувьд хараат бус гишүүндэд Алтансүвд, Амарсанаа, Одням ердийн гишүүнд Лхагвадорж, Цэндбаяр, Даваасүрэн Намуун, Энхсайрхан, ТУЗ-ийн даргаар миний бие Даянбилгүүн ажилласана байна. Санхүүгийн тайланд Далайн ван аудитын компаниар аудитаа хийлсэн. Хараат бус дүгнэлтийн хувьд сая гүйцэтгэх захирлын тайланд дурьдагдсан. Женкотур бюро ХК-ийн нэр дээр байдаг зарласан боловч гаргаагүй хувьцааны бүртгэл байдаг. Энэ нь хөрөнгийн биржийн веб сайт болон холбогдох газрууд дээр сая хурлын ирц мэдээлэлхэд хэлсэн саналын эрх бүхий 79,988,802 ширхэг хувьцаа 100,000,000 гэдэг тоотой зөрж байгаа учир аудитын хязгаарлалттай дүгнэлт гаргасан байгаа. Энэ дүгнэлтийн дагуу ойрын хугацаанд энэ тоог өөрчлөх, ТУЗ-ийн зарим гишүүдийн санал болохоор энэ хувьцааг зах зээлд гаргаж борлуулахыг тодорхой хэмжээнд хүлээн гэсэн нь одоо шаардлага байхгүй ХЭ-ийн зүгээс дахиж нэмж хувьцаа гаргах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үедээ СЗХорооноос зөвшөөрөл авах байдлаар дахин хувьцаа гарах бүрэн бололцоотой. Тиймээс хязгаарлалттай аудитын дүгнэлтийн нэн яаралтай залруулах хэрэгтэй байгаа. Үйл ажиллагааны төлөвлөгөөний тухайд бол ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс нийт 10 удаа хуралдсан байдаг. Энэхүү хурлаар гүйцэтгэх удирдлагын багт чиглэл өгөх заавар зөвлөгөө, хамтран ажиллах, бололцоог хангах, санхүүгийн чиглэлээр хамтран ажилласан байгаа. Энэ үүднээсээ цэвэр ашгийн хэмжээ нэлээд нэмэгдсэн байгаа тул гүйцэтгэх удирдлагыг нөөц бололцоогоо хангалттай ашигласан гэж ТУЗ-өөс дүгнэсэн байгаа.

Одоо 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын тайланг ерөнхий нягтлан танилцуулна.

Ерөнхий нягтлан: Аудитын компаниас тодорхой хэмжээний зөвлөмжүүдийг өгсөн байгаа. Зөвлөмжийн дагуу компанийн гүйцэтгэх удирдлага төлөвлөгөө гаргаж түүнийгээ ТУЗ-руу илгээж ТУЗ-аас зөвшөөрсний дагуу дараах зөвлөмжийн дагуу төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. 2019 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон компанийн санхүүгийн тайланд “Далайван Аудит” ХХК ажиллан аудит хийж гүйцэтгэсэн. Хөндлөнгийн аудитын дүгнэлтээр компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж тайлбарыг өгсөн байгаа. Бид 2018-2019 оны гүйцэтгэлийг харьцуулалт хийсэн. 2019 оны нийт орлогын гүйцэтгэлийг 2018 оны нийт орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад -2% бууралттай байгаа. Гол шалтгаан нь гадаад аялал нь үр ашиггүй байдал нь буурснаар 2 хувь буурсан. 2019 оны нийт зардлын гүйцэтгэлийг 2018 оны нийт зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад -25% бууралж танасан. Шалтгаан нь ашиггүй ажилласан өртөгүүдийг бууруулж ажилласантай холбоотой. 2019 оны нийт цэвэр ашгийн гүйцэтгэлийг 2018 оны нийт ашгийн гүйцэтгэлтэй харьцуулахад 520% өсөлттэй гарсан.

2019 төлөвлөгөөний гүйцэтгэлийн харьцуулалт

- 2019 оны нийт орлогын төлөвлөгөөг - нийт орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 17% биелсэн,
- 2019 оны нийт зардлын төлөвлөгөөг - нийт зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад 0,2% биелсэн,
- 2019 оны нийт цэвэр ашгийн төлөвлөгөөг - нийт цэвэр ашгийн гүйцэтгэлтэй харьцуулахад 116% биелсэн,

Хурлын дарга: 2020 оны санхүүгийн төлөвлөгөөг гүйцэтгэх захирал Энхсайхан танилцуулна.

Энхсайхан: 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг товч танилцуулъя. 2018 2019 оны гүйцэтгэл, гадаад дотоод орчин мөн ялангуяа аялал жуулчлалын салбарт үзүүлэх нөлөөллүүдийг үндэслэн орлогоо тогтворжуулан зардлаа хэмнэе гэсэн зорилготойгоор бид ажиллаж байна. Мөн ажилчдын ур чадварыг сайжруулах маркетингийн оновчтой бодлогуудыг хэрэгжүүлэх гээд бүлэг болон 161 ажлуудыг 2020 оноос төлөвлөн ажиллаж эхэлсэн. Гэвч COVID-19 нөлөөгөөр зарим төлөвлөсөн ажлууд хасагдах байдалтай явж байгаа. Гэхдээ үүнийг бид алдагдал гэж үзэхгүйгээр дотооддоо аялал жуулчлалыг хөгжүүлэх ажил дээр анхаарч томоохон төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. 2019 оны сүүлээр төлөвлөж байснаар томоохон тоо тавьсан боловч одоогоор багасаж гарч ирэхээр тооцоо гарч ирээд байгаа. Ойролцоогоор 1,3тэрбум ашигтай ажиллахаар төлөвлөсөн. Үүнээс санхүү болон үйл ажиллагааны зардлыг нэлээд сайн танаж ажиллах шаардлагатай байгаа. Борлуулалтаа 5,4 тэрбум байхаар төлөвлөж ажиллан гэсэн боловч төлөвлөгөө биелэх боломжгүй харагдаж байгаа. Компани маань COVID-19 ийн нөлөөгөөр алдагдалгүй ажиллахын төлөө хамт олон маань чармайн ажиллах болно гэдгийг та бүхэнд уламжлаж байна.

Хурлын дарга: Борлуулалт, цэвэр ашгийн хэмжээ багасна гэж оруулж ирнэ. Бүх л байгууллага дээр яригдаж байгаа ажиллагсадын ажлын байрыг авч үлдэх эсэх тодорхой энэ жилийн онцлого бодлого юу байна? Санхүүгийн зардлуудыг зайлшгүй бууруулах шаардлагууд ТУЗ-ийн гишүүдийн зүгээс тавигдаж байгаа. Энэ тал дээр шинэ үеийн нөхцөл байдлын талаар танилцуулаач?

Ерөнхий нягтлан: Өмнөх гаргаж байсан төсөв, коронатай холбоотой үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалаад бид аль болох санхүүгийнхаа үзүүлэлтийг эерэг үзүүлэлтийн ямар түвшинд хүргэж ажиллах вэ гэдэг төсөөллийг урьдчилсан байлаар гаргасан. 2020 онд бол 1,8 тэрбум төгрөгний борлуулалт хийхийн төлөө баг хамт олон маань хичээж ажиллахаар тодорхой хэмжээний жижиг төслүүд бэлдээд явж байгаа. Зардлын хувьд хамгийн бага түвшинд байхаар төлөвлөөд 1,7 тэрбум төгрөг байхаар төсөвлөсөн. 2020 ашиг маань 25,9сая төгрөг байхаар урьдчилсан таамаг дэвшүүлсэн байгаа. Энэ тухай ТУЗ-ийн хурал дээр өмнө нь танилцуулсан. Нөхцөл байдлаас шалтгаалан тухайн үедээ тодотгол хийгээд явъя гэдэг шийдэл хүрээд ажиллаж байна.

Энхсайхан: COVID-19тэй холбоотойгоор ажиллагсдын хязгаалалттай ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар ЧХМХ-ний цогцолбор болон 13р зуун маань хаалттай байгаа. Гэвч энэ хугацаанд бид нар өөрсдийн бололцоогоор засвар, үйлчилгээ, засаж сэлбэх ажил зэргийн ажилчдын хүчээр хийж байна. Мөн ажилчдыг халах арга хэмжээ авсангүй, аль болох ажлын байгаа хадгалж үлдэж, тэднийг ээлжээр ажиллуулж, амралтыг нь болоогүй хугацаанаас нь өмнө өгч, нэг хүн 2-3 ажлын байр дээр тогтвор суурьшилтай ажиллуулах зэрэг арга хэмжээг аваад явж байгаа. Үндсэн гол борлуулалтын орлого маань 2020 оны зуны улирал хэрэв COVID-19 тархаахгүй одоогийн хэмжээндээ аваад явбал тодорхой хэмжээгээр үйл ажиллагаа сэргэнэ гэдэг үүднээс дотоод аялалыг хөгжүүлэн ажиллахаар анхаарч байна. Түүнчлэн говийн бүс, хэнтий, баруун аймаг, хойд зүгийн бүсүүдэд аялал жуулчлалыг хөгжүүлэх болон байгаль орчны яам, аялал жуулчлалын холбоогоос өгсөн зааварчилгааны дагуу энэ бүх зохион байгуулж байгаа үйл ажиллагаа дээр хамтран баг хамт

олноороо энэ вирусын нөлөөг даван гарахын төлөө ажиллана гэдэг зорилттой байна. Эх орондоо зохиож болох сонирхолтой арга хэмжээнүүдийг 13-р зуун дээрээ зохион байгуулахаар төлөвлөж байгаа.

Хурлын дарга: ХЭ нар сонирхож асуух асуулт байгаа байх. Энэ COVID-Ийн үед төр засгийн зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ манай компанид хэр зэрэг хүрч байгаа вэ төр засгийн зүгээс дэмжлэх тусламж өгч байгаа юу? Зам дагуу чингисийн хөшөө дээр хэрэгжих төсөл төлөвлөгөө явагдаж байгаа. Энэ дээр манай компанийн зүгээс хамтарч ажиллах бололцоо юу байгаа вэ? Манай компанид наалдах наалдац юу байна?

Энхсайхан: 2020 онд аялал жуулчлалын газар болон худалдаа аж үйлвэрийн тэнхимтай тодорхой хэмжээний гэрээтэй болон гишүүнээр ажилладаг. Үүнд ХАҮТ-аас зохион байгуулахаар төлөвлөж байсан нэлээд ажлууд вирусээс болж цуцлагдсан байгаа. Дотоод аялал жуулчлалдаа зориулан төлөвлөгөө гарган ажиллана. ХАҮТ, аялал жуулчлалын холбооноос өгч байгаа зааврын дагуу COVID19-ийг хэрхэн давч туулах вэ гэсэн зарчим дээр үндэслээд хамтран ажиллаж байна. Төр засгийн зүгээс тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээлүүдийг санал болгож байгаа. Ногоон төслүүдийг санал болгосон байдаг. Бид энэ бүхэнд хамрагдахаар санал хүсэлтээ өгөөд явж байгаа.

Хурлын дарга: ТУЗ-ийн зардлыг ХЭ-аар батлуулдаг байгаа. Ердийн гишүүд цалин авахгүй сүүлийн хэдэн жил явж байгаа. Зөвхөн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн зардал сарын 250,000 төгрөг, Хараат бус 3 гишүүн байгаа. ТУЗ-ийн нарийн бичиг сарын 350,000, ТУЗ улиралдаа хамгийн багадаа нэг удаа хуралдах зардал 150,000 төгрөг, өнгөрсөн жил бид 10 удаа хуралдсан байдаг. Тэгэхээр энэ тоо нэмэгдэх болов уу.

№	Зардлын нэр	Тоо	Сарын	Жилийн	Нийт
			зардал	зардал	(төгрөг)
1	ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин	3	250,000	3,000,000	9,000,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн цалин	1	350,000	4,200,000	4,200,000
3	ТУЗ-ийн хурлын зардал	4	150,000	600,000	600,000
	Нийт		850,000	7,800,000	13,800,000

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийн танцуулга.

ТУЗ-ийн ердийн гишүүнд дараах нэр дэвшигч нар дэвшиж байгаа.

Д.Даянбилгүүн, Д.Даваасүрэн Д.Батжаргал Н.Батгэрэл, Б.Лхагвадорж, Б.Намуун, Ц. Энхсайхан

Хараат бус ТУЗ-ийн гишүүдэд

Б.Алтансүвд, Б.Амарсанаа, Б.Золжаргал, Т.Одням, Г.Өсөхбаяр

Шинээр нэр дэвшиж байгаа Д.Батжаргалыг СЭЗС-ийн захирал, туршлагатай эдийн засагч гэдгээр нь та бүхэн мэдэж байгаа. Б.Намуун жирэмсний амралтаа дуусгаад компанийн гүйцэтгэх захиралд эргэж ирэх өргөдлөө өгөөд ажилдаа орж байгаа.

Дээрх нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулгыг ХЭ та бүхэн хурлын номноос хараарай. Эдгээр нэр дэвшигчдээс сонгох саналаа өгөхдөө та бүхэн тооллогын комиссын зааврын дагуу саналын хуудсаа алдаа мадаггүй бөглөөрэй.

Хурлын дарга: ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараах тухай шийдвэрийг танилцуулах.

Энэ жил компани түүхэндээ хамгийн өндөр ашигтай ажилласан жил байсан. ХЭ маань олон жил ашиг авч байгаагүй. Тараасан ногдол ашиг бага байсантай холбоотой энэ жил түүхэнд өндөр ногдол ашиг буюу нэгж хувьцаанд 10 төгрөг тараах шийдвэрийг ТУЗ гаргасан байгаа.

Энхсайхан: Ногдол ашгийн шийдвэрийг уншиж танилцуулав.



**“ЖЕНКО ТУР БЮРО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар1.....

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол улсын компаний тухай хуулийн 46-р зүйлийн 46.5 дахь заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 сарын 19-ний өдрийн хурлын санал хураалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Женко тур бюро” хувьцаат компанийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 10 /Арван/ төгрөгийг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашигт хуваарилахаар тогтоосугай.
2. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэснийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн Удирдлах Зөвлөлийн дарга /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.
3. Ногдол ашиг тараах түүнтэй холбогдох ажлыг гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал Ц.Энхсайхан-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА / Д.ДАЯНБИЛГҮҮН /



Чингис Хааны өргөн чөлөө, Ш/Х-43, Баянгол Оффис 1 давхарт, Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: 976-7012-0202 Факс: 976-11321705
И-Шуудан: info@genco-tour.mn www.genco-tour.mn

Хурлын дарга: Энэ дээр нэг асуудал байгаа нь Компанийн зүгээс ХЭ хурал маань нэг удаа хойшилсон байгаа учраас ХЭХурал дээр ногдол ашиг тараах,түүнийг хэзээ, хэдийн тодор тараах шийдвэрийг бас танилцуулах ёстой байх.

Энхсайхан: Одоогоор өдөр товлоогүй.

Хурлын дарга: Тэгвэл 5 сарын 30-ний дотор хэзээ тараах хугацаагаа тогтоогоод ХЭ хурал дээрээ танилцуулъя.

За ингээд хурлын зүгээс онлайнаар явагдаж байгаа энэ хурлын шийдвэр, танилцуулга үйл ажиллагааны тайлангуудыг танилцуулж дууслаа.

За 10 минутын хугацаанд асуулт хариулт явуулъя. Шууд видеогоор холбогдож болно. Мөн чатаар холбогдож болно.

Хувьцаа эзэмшигч: 85 сая төгрөгний ногдол ашгийг бүртгэлээс хассан байна энэ ямар учиртай вэ?

Хувьцаа эзэмшигч: Хувьцааны тооны зөрүү гэж ярьлаа. Энэ талаар тордуулж өгнө үү?

Хурлын дарга: Зарласан боловч гаргаагүй байгаа хувьцаа байгаа. Анх хувьцаат компани болохдоо 100 сая ширхэг хувьцаа гаргая гэж 2006 онд СЗХорооноос зөвшөөрөл авч олон нийтэд зарласан байдаг. Зарагдаж компанид хөрөнгө оруулалт болж орсон нь 79,982,802 ширхэг хувьцаа эргэлтэнд орж зарагдсан. Үлдсэн 20 сая орчим хувьцаа маань олон нийтэд арилжигдаагүй, хэн нэгэн аваагүй, бид тодорхой хэмжээнд гольф, спа төслийг хэрэгжүүлж хөрөнгө зарцуулалт хийе гэж байсан боловч эдгээр төслүүд яваагүй улмаас энэ хувьцааг гаргаж зараагүй КТХ-ийн дагуу гаргаагүй халаасны хувьцаа маягаар байсан. Энэ байдлаар 2006 оны зөвшөөрөл маань өнөөдрийг хүрчихсэн байдаг. Хороо, болон биржийн зүгээс компанид шаардлага хүргүүлсэн байдаг. Энэ хувьцаагаа нэг бол дүрмээсээ хас, үгүй бол гаргаж болно гэсэн. Өнөөдрийн нөхцөл байдлын улмаас хувьцааны ханш бага байгаа учир гаргаж зарахгүй, харин бүртгэлийг зөрүүтэй байдлыг зөв болгох байгаа. Дүрмээсээ бол хасчихсан байгаа. Түрүүний 85сая төгрөгний ногдол ашиг гэдэг нь энэ хувьцаан дээр тооцогдож байгаа ногдол ашиг, санхүүгийн бүртгэл нь буруу хийгдсэн байсан. Энэ тараах ногдол ашиг биш, компанидаа үлдэнэ. Хүчингүй болгосон нь ийм шалтгаантай.

Хувьцаа эзэмшигч: Зарласан боловч гаргаагүй хувьцаа гэж ТУЗ-ийн даргын танилцуулгад гарлаа. Нэмж хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн гэсэн үг үү?

Хурлын дарга: Компанийн зүгээс өнөөгийн нөхцөл байдал, хөрөнгийн зах зээл болон гадаад дотоод хөрөнгө оруулалтыг харж байгаа энэ нөхцөлд хувьцаа гаргах ойрын төлөвлөгөө байхгүй. Тодорхой хэмжээнд 2019 онд ТУЗ дээр маш их яригдсан боловч хийж чадаагүй зүйлүүдийг нэг ЧМХ цогдолборыг илүү үр ашигтай, жуулчдад үйлчилгээгээ сайн хүргэж чадсан, компанид ашигтай төслүүдийг хэрэгжүүлбэ, зээлийн санхүүжилтээр ч үүнийг хийх боломжтой, хэрэв төслүүдээ хэрэгжүүлбэ гэвэл нэмж хувьцаа гаргах асуудал яриглах байх. Гэхдээ энэ жил ямар нэг төлөвлөгөө байхгүй байна. ТУЗ-өөс эхэлж төлөвлөгөөгөө батлах хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч: Гадаад иргэдэд хувьцаагаа хэрхэн тараах вэ?

Хурлын дарга: СЗХорооны шинэ журам гарсан. Ногдол ашгийг ҮЦТТХТ-өөр дамжуулан шууд тараахаар болсон. Гадаадын хөрөнгө оруулагч иргэд хувьцааны данснаасаа шууд авах боломжтой хувьцааны данснууд DVP шинэ систем руу шилжсэн. Иймээс дансаа шинэчлэн брокерын компани тайгаа гэрээгээ байгуулсан байх хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч: Covid19-ийн нөлөөлөл буурч аялал жуулчлалын гадаад зах зээл боломжтой нээгдтэл дотоодын аялал жуулчлалыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулахад анхаарвал

хэрэглэгчдийн сонирхолд нийцэх мөн компанид кардал бууруулах боломж гарах болов уу гэсэн санал байна. Уучлаарай санал авах тусгай цаг байгаа билүү?

Хурлын дарга: ХЭ-ийн зүгээс компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой саналууд тавьдагт их талархдаг. Би бол энэ салбарт мэргэжлийн хүн биш. Хөрөнгө оруулагч, ХЭ-ийг төлөөлж байдаг. Компанийн зүгээс мэргэжлийн ажилчид энэ дээр сууж судалгаа хийж ямар аялалууд компанид үр ашигтай байж болох уу? Аялалыг хэрхэн амжилттай зохион байгуулах уу? Гэдэг дээр байнга ажилладаг. Яг илүү тодорхой хамтран ажиллах, ийм байдлаар ажиллавал ашгийн нэмэгдүүлэх зардлыг бууруулах санаанууд байна гэвэл компанийн зүгээс нээлттэй. Одоогоор гадаад аялал хаагдчихсан байгаа. Тиймээс дотоод аялал дээр илүү төвлөрч арга хэмжээнүүдийг хэрхэн зохин байгуулах уу. Гэдгийг аль болох ашиглах байх. Хотын ойролцоо амралтын газрууд нээгдэж үйл ажиллагаа явуулж байгаа. Бид олон хүн хамруулахгүй гэхдээ тодорхой тооны хүмүүс цар тахлын аюул дэгдээхгүй хэмжээнд ажиллах тал гүйцэтгэх удирдлагын бага ажиллах байх. Энэ дээр ашиг орлого нэмэгдүүлэх тооцоо байгаа гэж харж байна.

Өөр асуулт ирээгүй учраас тооллогын комиссын тогтоолыг танилцуулах, хурлаар гарах шийдвэрийг танилцуулах, хурал хаах гэсэн ажил үлдлээ.

Тооллогын комисс:

“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН ХОЙШЛОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

2020 оны 05 сарын 13 өдөр

Улаанбаатар хот

“Женко тур бюро” ХК-ийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

“Женко тур бюро” ХК-ийн саналын эрхтэй нийт 79,988,802 ширхэг хувьцаанаас 83.6 % буюу 66,872,680 ширхэг хувьцаа эзэмшиж буй 52 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 73.75 % буюу 49,319,673 ширхэг хувьцаатай 47 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,319,673	100%	0	0%	0	0%

2. Компанийн 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 83.99% буюу

56,169,673 ширхэг хувьцаатай 48 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 87.80% зөвшөөрсөн, 12.19% татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,319,673	87.80%	6,850,000	12.19%	0	0%

3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 73.75% буюу 49,319,673 ширхэг хувьцаатай 47 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 40.63% зөвшөөрсөн, 59.36% татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
20,039,384	40.63%	29,280,289	59.36%	0	0%

4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 73.75% буюу 49,319,673 ширхэг хувьцаатай 47 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, 0 % татгалзсан, 0 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
49,319,673	100%	0	0%	0	0%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 83.09 % буюу 66,463,997 ширхэг хувьцаатай 45 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн санал:

Ердийн гишүүдэд:

	ТУЗ-ийн ердийн гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Нарангэрэл БАТГЭРЭЛ	14.687%	58,571,208

2	Дорлигжав БАТЖАРГАЛ	14.676%	58,527,351
3	Дашцэрэн ДАВААСҮРЭН	8.778%	35,007,836
4	Данзан ДАЯНБИЛГҮҮН	14.686%	58,569,237
5	Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ	14.685%	58,563,917
6	Баттулга НАМУУН	15.410%	61,454,742
7	Цэнд ЭНХСАЙХАН	17.074%	68,089,391

Хараат бус гишүүдэд:

	ТУЗ-ийн хараат бус гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
8	Баярсайхан АЛТАНСУВД	29.950%	59,718,897
9	Балжинням АМАРСАНАА	0.009%	18,837
10	Тэгшээ ОДНЯМ	18.209%	36,308,808
11	Банзрагч ЗОЛЖАРГАЛ	25.940%	51,722,645
12	Ганболд ӨСӨХБАЯР	25.890%	51,622,654

тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Ердийн гишүүнд:

1. Нарангэрэл БАТГЭРЭЛ
2. Дорлигжав БАТЖАРГАЛ
3. Данзан ДАЯНБИЛГҮҮН
4. Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ
5. Баттулга НАМУУН
6. Цэнд ЭНХСАЙХАН

Хараат бус гишүүнд:

1. Баярсайхан АЛТАНСУВД
2. Банзрагч ЗОЛЖАРГАЛ
3. Ганболд ӨСӨХБАЯР

Тооллогын комиссын дарга:

/О.Баярцэцэг /

Тооллогын комиссын гишүүд:

/Б.Эрдэнэдалай/

/О.Өнөрчимэг/

/Л.Хүрэлсүх/

/Б.Тэмүүлэн/

Хурлын дарга: ХЭ-ийн хурлаар санал хураалт амжилттай явагдаж дууслаа. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүддээ ажлын амжилт хүсч, компанийг үр ашигтай хамтран ажиллах болсонтой талархаж байна. Бүгдэнд амжилт хүсье. Шинээр ТУЗ-д сонгогдсон гишүүд Д.Батжаргал, Г.Өсөхбаяр, Золжаргал, Н.Батгэрэл нар сонгогдсон байна. За тогтоол уншиж танилцуулъя.

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, “Женко тур бюро” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй.

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах

“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

“Женко тур бюро” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай

“Женко тур бюро” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудлаар нийт 49,322,873 ширхэг хувьцаатай 48 хувьцаа эзэмшигчид хүчинтэй санал өгснөөс 59.36% нь татгалзсан тул тус асуудлыг батлагдахгүй болохыг мэдэгдсүгэй.

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлж шийдвэрлэсүгэй.

“Женко тур бюро” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсөв батлах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, “ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

“Женко тур бюро” Хувьцаат компанийн 2020 оны төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг 13,800,000 / Арван гурван сая найман зуун мянган/ төгрөгөөр хавсралт №1-ээр баталсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 1 дэх хэсгийн 7 дэх заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Женко тур бюро” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Женко тур бюро” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр

1. Н.БАТГЭРЭЛ
2. Д.БАТЖАРГАЛ
3. Д.ДАЯНБИЛГҮҮН
4. Б.ЛХАГВАДОРЖ
5. Б.НАМУУН
6. Ц.ЭНХСАЙХАН

Хараат бус гишүүнээр

7. Б.АЛТАНСУВД
8. Б.ЗОЛЖАРГАЛ
9. Г.ӨСӨХБАЯР нарыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

/Д.ДАЯНБИЛГҮҮН/

Хурлын дарга: Хойшлогдсон ХЭ-ийн хуралд онлайн горимоор оролцсон, санал, зөвлөмжөө өгсөн, саналын хуудсаар оролцсон та бүхэндээ талархсанаа илэрхийлье. Шинээр ТУЗ-д сонгогдсон гишүүд, ажлын хамт олон амжилт хүсч, COVID-19 даван туулж, компани ашигтай ажиллан 2020 онд ногдол ашиг хуваарилах болтугай гэж хүсэн ерөөе.

Өнөөдрийн ХЭХурал хаасныг мэдэгдье.

Хурлын дарга:...../Д.Даянбилгүүн/

Тэмдэглэл хөтөлсөн:...../Б.Түвшинбаяр/